

АРИУН СҮМД  
ОРОХОД БЭЛТГЭХ НЬ



АРИУН СҮМД  
ОРОХОД БЭЛТГЭХ НЬ

Энэ товхимлыг  
Бойд К.Пакерын *Ариун Сүм*  
номноос хялбаршуулан авсан болно.

нүүрэн талын хавтас: Солт Лэйкийн Ариун Сүм  
ар талын хавтас: Лаиэ Хавайн Ариун Сүм

© 2002 Intellectual Reserve, Inc.  
Бүх эрхийг эдэлнэ  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 8/02  
Орчуулгын зөвшөөрөл: 8/02  
*Ариун Сүмд Ороход Бэлтгэх нь*-ийн орчуулга  
Mongolian

## АРИУН СҮМД ОЧИГТУН

Хүн ариун сүмд явахыг хүсдэг шалтгаан олон янз юм. Тэр ч байтугай ариун сүмийн гадаад төрх байдал нь гүнзгий сүнслэг зорилгыг төрүүлэхээр байдаг. Энэхүү сүнслэг зорилго дотор нь бүр ч илүү мэдэгддэг. Ариун сүмийн хаалганы цаана “Их Эзэнд Ариун” хүндэтгэл нүднээ тусна. Та аль ч онцгойлон адислагдсан ариун сүмд орлоо гэхэд та Их Эзэний Өргөөнд байх болно.

Сүмд бид олон янзын барилга байгууламж барьдаг. Эдгээрт бид шүтэн биширч, зааж, чөлөөт цагаа идэвхтэйгээр өнгөрүүлж, ажил зохион байгуулдаг. Эдгээр барилгуудад буюу тэр ч байтугай түрээсэлсэн барилгуудад бид гадас, хэсэг, номлол, чуулга хийгээд Нийгмийн Халамжийн Бүлгүүдийг зохион байгуулж болно. Гэвч бид Их Эзэний илэрхийлсэн журмын дагуу гэр бүлүүдийг зохион байгуулахдаа тэдгээрийг ариун сүмүүдэд зохион байгуулдаг. Ариун сүмийн гэрлэлт, холболтын ёслол бол ариун сүмд таны хүртэж болох эрхэм дээд адислал мөн.

Өөрсдийгөө зохистой авч явдаг Сүмийн гишүүд хүмүүн төрөлхтөнд илэрхийлэгдсэн цагаатгалын ёслолуудаас хамгийн дээд өргөмжлөгдсөнд нь ариун сүмүүд дотор оролцож чадна. Энд, ариун нандин ёслолд хувь хүн угаагдаж, тослогдож, зааварлагдан, мөн индаументаа хүртэж, холбогдож болно. Бид эдгээр адислалуудыг өөрсдийнхөө төлөө хүлээн аваад, мөн ийм боломж олдолгүйгээр нас барсан хүмүүсийн өмнөөс ёслолуудад оролцож болно. Ариун сүмүүдэд амьд байгаа болон нас барсан хүмүүст адилхан ариун нандин ёслолуудыг гүйцэтгэдэг. Энд хөшигний цаана гарч явж одсон хүмүүсийн төлөө зохистой гишүүд итгэмжлэгдэн үйлчилж, нас барагсдын өмнөөс үйлддэг усан баталгааг хийх усан баталгааны сан байдаг.

“Ариун сүмд очигтун.” Одоо биш гэхэд удалгүй оч. Ихэд хичээнгүйлэн залбир, амьдралаа төвхнүүл, мөн тэр өдөр ирнэ гэдэгт найдан хэмээн чадах бүхнээ хэмнэн хадгал. Зарим үед хэцүү, бас зориг мохоодог наманчлалын аянг одооноос эхэл. Ариун сүм хувь хүнийг өөрчилж, тэнд очихын тулд аливаа хүчин чармайлт гаргах хүсэл эрмэлзлийг нь туйлын их болгодог. Ариун сүмээс алс хол байдаг та нарын хувьд та нарыг ариун сүмүүдэд очихоос өмнө тэдгээр нь та нар дээр ирэх болно. Итгэл хийгээд найдвартай байж, тийшээ явна, мөн та нар зохистой байна, мөн ариун сүм рүү явна хэмээн шийдвэр төгс бай.

## *ЭДГЭЭР ЗҮЙЛҮҮД НЬ НАНДИН ЮМ*

Судруудыг анхааралтай унших нь Их Эзэн бүх зүйлийг бүх хүмүүст хэлээгүйг илчилдэг. Ариун нандин мэдээллийг хүлээн авахын тулд зарим нэг болзлыг угтвар нөхцөл болгон тогтоосон байдаг. Ариун сүмийн ёслолууд энэ төрөлд багтдаг билээ.

Бид ариун сүмээс гадуур ариун сүмийн ёслолуудын талаар ярилцдаггүй. Ариун сүмийн эдгээр ёслолуудын тухай мэдлэгийг сонгогдсон цөөхөн хүмүүсээр хязгаарлагдаж, эдгээр хүмүүс тэдгээр ёслолуудын талаар бусдад хэзээ ч мэдэгдэхгүй байх үүрэг хүлээх ёстой гэсэн зорилго хэзээ ч байгаагүй. Үнэндээ энэ нь үүнээс өөр зүйл юм. Бид хүн бүрийг ариун сүмд ороход бэлтгэн, шаардлага хангасан байхад нь урамшуулж ихээхэн хүчин чармайлт гаргадаг билээ. Ариун сүмд орсон хүмүүс нэг төгс зүйлийг мэдэж авдаг нь юу гэвэл: Нэгэн цагт, эдүгээ амьд байгаа хүн бүхэн, бас өмнө нь амьдарч байсан хүн бүхэн сайн мэдээг сонсох хийгээд ариун сүмийн санал болгож байгаа зүйлийг хүлээн авах буюу няцаах боломжтой болно гэсэн ойлголт юм. Хэрэв энэхүү боломж няцаагдах аваас, түүний хариуцлагыг хувь хүн үүрэх ёстой байдаг.

Ариун сүмийн ёслолууд хийгээд дэг жаяг нь энгийн юм. Тэдгээр нь сайхан. Тэдгээр нь ариун нандин. Тэдгээрийг чанд хадгалдаг, эс бөгөөс тэдгээр нь хүлээн авахад бэлтгэгдээгүй хүмүүст хүртээгдэнэ. Ариун сүмийн ёслолуудад сониуч зангаар хандах нь бэлтгэл биш. Гүн гүнзгийгээр со-

нирхох нь ч бас бэлтгэл биш. Ёслолуудад бэлтгэх урьдчилсан үе шатууд нь: Их Эзэний Өргөөнд уригдан орж байгаа тэр хүний итгэл, наманчлал, усан баталгаа, гишүүний баталгаа, зохистой байдал, биеэ зөв авч явах хийгээд түүний боловсорч хөгжсөн байдлыг багтаадаг.

Бид ариун сүмд орохоосоо өмнө бэлтгэгдсэн байх ёстой. Бид ариун сүмд орохоосоо өмнө зохистой байх ёстой. Үүнд хязгаарлалтууд болон болзлууд байдаг. Тэдгээр нь хүмүүнээр биш, харин Их Эзэнээр тогтоогдсон юм. Мөнхүү, ариун сүмтэй холбоотой асуудлуудыг ариун нандин чигээр нь чанд сахих тэрхүү бүхий л эрх мэдэл Их Эзэнд байдаг.

Ариун сүмд орох зохистой бөгөөд шаардлага бүрийг хангаж буй бүх хүмүүст тэрхүү ариун нандин ёс жаяг хийгээд ёслолуудыг тэнд танилцуулдаг.

## *ОРОХОД ЗОХИСТОЙ БАЙХ*

Ариун сүмийн адислалууд хийгээд ариун сүмд хийгддэг ёслолуудын ариун нандин байдлын үнэ цэнийг та хүлээн зөвшөөрч, тэдгээрийн талаар зарим ойлголттой болохоороо ариун сүмд орохын тулд Их Эзэний үндэслэсэн тэр өндөр жишгүүдийг хангах эргэлзээгүй байх болно.

Та ариун сүмд орохын тулд хүчин төгөлдөр зөвшөөрлийн бичигтэй байх ёстой. Зөвшөөрлийн бичигт танай хэсгийн бишоп болон гадасны ерөнхийлөгч гарын үсэг зурсан байх ёстой. Номлолын талбарт, мэдээж хэрэг, салбарын ерөнхийлөгч, мөн номлолын ерөнхийлөгч нь ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олгох үүрэгтэй байдаг. Зөвхөн зохистой хүмүүс л ариун сүмд орох ёстой. Бишоп нь бидний хувийн зохистой байдлын талаар асуулт тавих үүрэгтэй байдаг. Энэ ярилцлага Сүмийн гишүүн таны хувьд амьдралынхаа чиг хандлагыг Их Эзэний томилогдсон үйлчлэгчтэй хамт шалгаж байгаа хэрэг учраас онцгой чухал ач холбогдолтой юм. Хэрэв амьдралд чинь ямар нэг буруу зүйл байвал, үүнийг шийдэхэд тань бишоп тусална. Энэ журмын дагуу та Израилын олон нийтийн шүүгчтэй зөвлөлдсөнөөрөө та Их Эзэний батлан дэмжсэнээр ариун сүмд орох өөрийн зохистой байдлыг тунхаглах буюу үүнийг тогтооход туслуулж болно.

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөхөөр үйлчилж асан, ерөнхийлөгч Н.Элдон Таннер пристийн зэрэгтний ерөнхий хуралдаан дээр ярилцлагын тухай дурдсан байдаг. Ярилцлага хийж байгаа Сүмийн удирдагчид, ярилцлагад орох гэж байгаа гишүүдийн аль алиных нь хувьд түүний өгсөн зөвлөгөө ач холбогдолтой юм. Энэ зөвлөгөөг сайтар бодож үзээрэй:

Бишопын зөвлөл болон гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн та нар ариун сүмийн зөвшөөрөл олгох ярилцлагыг иймэрхүү байдалтай хийж болно:

“Та ариун сүмд орох зөвшөөрлийн бичиг авахаар над дээр ирээд байна. Тантай хийх ярилцлагад би Их Эзэнийг төлөөлөх үүрэг хариуцлагатай. Ярилцлагын эцэст таны зөвшөөрлийн бичигт би гарын үсэг зурах ёстой; гэвч таны зөвшөөрлийн бичиг дээр зөвхөн би гарын үсэг зурах нь ач холбогдолтой биш юм. Зөвшөөрлийн бичиг хүчин төгөлдөр байхын тулд та өөрөө гарын үсэг зурах ёстой.

“Зөвшөөрлийн бичигт гарын үсэг зурснаараа та уг зөвшөөрлийн бичгийг эзэмшигчдэд олддог тэрхүү онцгой эрхийн хувьд та зохистой гэдгээ Их Эзэнд нотолж байгаа юм. Би танаас хэдэн жишиг асуултуудыг асууна. . . . Та эдгээр асуулт бүрд шударгаар хариулах ёстой.” . . .

Одоо, та эдгээр шаардлагатай асуултуудыг хүсэлт гаргагчид тавьсны дараа иймэрхүү зүйлийг нэмэн хэлж болно: “Их Эзэний өргөөнд орох хүн аливаа *муу муухай, цэвэр ариун бус, бузар булай буюу бусармаг зүйлээс* хол хөндий байх ёстой.” . . .

Бидний ярилцлага хайр, даруу төлөв байдалд явагдах ёстой. Хэрэв та: “Та өөрийнхөө ариун сүмийн зөвшөөрлийн бичигт гарын үсэг зурахдаа Их Эзэнд шударга бусаар хандсан хэрэг гэсэн эвгүй бодол төрөх ямар нэг шалтгаан танд байна уу? гэж асуувал байдлыг засч залруулах нь олонтаа байдаг.

“Та гарын үсэг зурахаасаа өмнө зарим зөвхөн хувийн зүйлүүдээ залруулах хугацаа авах уу? Их Эзэн бүх зүйлийг мэддэг бөгөөд шоолохгүй гэдгийг санагтун. Бид танд туслахыг хичээж байна. Их Эзэнээс дуудлага, зөв-

шөөрлийн бичиг эсвэл адис ивээл хүлээн авахын тулд хэзээ ч бүү худал хэл.”

Хэрэв та дээр харуулснаар асуудалд хандах юм бол, уг гишүүн өөртэйгөө ярилцлага хийх үүрэгтэй байх болно. Бишоп болон гадасны ерөнхийлөгч ялгаж таних хүчтэй байх эрхтэй. Тэрээр зөвшөөрлийн бичгийг олгохын өмнө шийдвэрлэвэл зохих ямар нэг буруу зүйл байгаа, үгүйг мэдэх болно” (“The Blessing of Church Interviews,” Ensign [November 1978]: 42–43.)

Ариун сүмийн зөвшөөрөл олгох ярилцлага нь зөвхөн бишоп, Сүмийн тухайн гишүүн хоёрын хооронд явагдана. Энд гишүүнээс асуух асуултууд нь түүний биеэ авч явах болон зохистой байдлын тухай, түүнчлэн Сүм болон ажилтнуудад үнэнч шударгаар ханддаг тухай байна. Тухайн хүн ёс суртахууны хувьд цэвэр ариун, Мэргэн Ухааны Үгийг дагаж, аравны нэгээ бүрэн төлдөг, Сүмийн сургаалуудын дагуу амьдардаг, мөн харш бүлгүүдтэй харилцаа холбоогүй буюу тэднийг дэмжин талархдаггүй гэдгээ нотлон харуулах ёстой. Ярилцагч болгонтой эдгээр асуудлуудыг шийдэхэд нууцыг хадгалах нь туйлын чухал гэдгийг бишопт зааварласан байх ёстой.

Бишопын асуултуудад хүлээн зөвшөөрч болохуйцаар хариулах нь ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахад тухайн хүн зохистойг ерөнхийдөө нотлон харуулдаг. Хэрэв хүсэлт гаргагч зарлигуудыг биелүүлдэггүй буюу зохицуулах, наманчлах шаардлагатай ямар нэг зүйл түүний амьдралд байгаа бол, ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олгохоос өмнө тухайн хувь хүн жинхэнэ ёсоор наманчлах нь түүний хувьд зайлшгүй хэрэгтэй.

Бишоп ийм ярилцлага хийсний дараа, биднийг ариун сүмд явахаас өмнө гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн бидний хүн болгонтой дээрх байдлаар ярилцлага хийнэ. Хэрэв бид анх удаа явж байгаа бол, ихэвчлэн гадасны ерөнхийлөгч өөрөө ярилцлага хийдэг.

Мэдээж хэрэг та ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахаар ярилцлагад орохдоо энэхүү ариун нандин газарт орох ёстой юу, үгүй юү гэдгийг тодорхойлох Их Эзэнийг төлөөлөх тэрхүү Израилын шүүгчийн шүүлтийг та өөр дээрээ хүлээн авах болно.





*Сэлэсчэл Өрөө, Ютагийн Вернал Ариун Сүм*

## ЭХНИЙ УДАА ТҮҮНЧЛЭН ТУХАЙ БҮР

Хэрэв та анх удаагаа ариун сүмд явах гэж байгаа бол тайван бус байх нь хэвийн зүйл юм. Бид мэдэгдэхгүй байгаа зүйлийн талаар үнэнхүү санаа зовдог. Ер нь бид шинэ тохиолдлын талаар сэтгэл зовдог.

Амгалан тайван байгтун. Та ариун сүмд явах гэж байна. Тэнд эргэн тойронд тань танд туслах хэн нэгэн байх болно. Таныг анхааралтайгаар удирдан хөтлөх болно— амар тайван байгтун.

Бид ариун сүмд орсон үедээ хүндэтгэлтэй байх ёстой. Ярих шаардлагатай боллоо гэхэд намуухан ярих ёстой. Заавар авч байгаа үедээ бид, мэдээж хэрэг, гүн хүндэтгэлтэй чимээгүй байх хэрэгтэй.

Нам гүм, хүндэтгэлтэй байх шардлагатай хэдэн газар байдаг. Зарим ариун сүмүүдэд ёслолын ажил эхлэхээр орохын өмнө нэг хэсэг болон орох гэж байгаа хүмүүс ариун сүмийн барилга доторх шүтээний танхимд цуглах нь олонтаа байдаг. Энд гишүүд бусдыгаа бүрэн цуглартал хүлээдэг. Ерөнхийдөө бид хүлээх тэвчээр муутай байх нь амьдралд байдаг зүйл. Өрөөнд хамгийн түрүүнд орж ирээд сүүлчийн хүнийг орж иртэл хүлээхээс өөр аргагүйд хүрэх нь өөр нөхцөлд бол бухимдал төрүүлэх зүйл мөн. Ариун сүмд бол энэ нь өөр юм. Хүлээхийг энд сонгох боломж гэж үздэг. Ярихгүйгээр чив чимээгүй сууж, бишрэл хүндэтгэл хийгээд сүнслэг бодлуудад оюун санаагаа хандуулна гэдэг юутай эрхэм завшаан билээ! Энэ бол оюун санаагаа сэргээн цэнэглэх мөч юм.

Та ариун сүмд орох үедээ өөрийгөө Их Эзэний өргөөнд ирсэн зочин гэдгээ санагтун. Энэ бол баяр баясгалангийн мөч, гэхдээ нам гүм баяр баясгалангийн мөч билээ. Зарим үед ариун сүмийн гэрлэлтийн үед удаан уулзаагүй гэр бүлийн тань гишүүд, төрөл төрөгсөд, найз нөхөд хайр, баяр талархлаа намуухан илэрхийлэхийг тэдэнд сануулах нь чухал. Чанга ярих, чанга инээх нь Их Эзэний өргөөнд үл нийцэх зүйл.

Ариун сүмийн ажилтнуудын заавар чиглүүллийг дагагтун. Хэн нэгэн танд газарчлах болно.

## ДЭЭД ТЭНГЭРЭЭС ЗААГДСАН

Энэ нь ариун сүмд анх удаа явахаасаа өмнө тэр ч байтугай олон удаа явсны дараа ч ариун сүмүүдэд заагддаг зүйл нь бэлэгдлийн байдлаар хийгддэгийг ухаарч ойлгоход танд туслах болно. Их Эзэн, Эзэн Багш, ийм байдлаар Өөрийн олон зааврыг өгсөн билээ.

Ариун сүм бол агуу сургууль мөн. Энэ бол суралцах өргөө. Ариун сүмүүд дэх уур амьсгал нь гүн гүнзгий сүнслэг зүйлүүдийг зааварлахад төгс үлгэр жишээ үзүүлэхүйц байдаг. Арван Хоёрын Чуулгын талийгаач Доктор Жон А.Видцое их сургуулийн алдар цуутай ерөнхийлөгч, дэлхий дахинаа нэрд гарсан эрдэмтэн байлаа. Тэрээр ариун сүмийн ажилд туйлын гүн хүндэтгэл бишрэлтэй ханддаг байсан бөгөөд энэ талаар ийн хэлсэн юм:

Сүмийн удирдагчид үеэс үед заадагчлан ариун сүмийн ёслолууд нь авралын төлөвлөгөөг нийтэд нь хамардаг бөгөөд ойлгоход хэцүү асуудлуудыг тодруулдаг. Ариун сүмийн сургаалуудыг авралын агуу их төлөвлөгөөтэй нийцүүлэхэд гажилт завхруулга байж болохгүй. Индаументийн гүн ухааны бүрэн төгс чанар нь ариун сүмийн ёслолуудын үнэнийг харуулах агуу их нотолгоонуудын нэг мөн Түүнээс гадна, энэхүү бүрэн төгс дүгнэлт болон сайн мэдээний төлөвлөгөөг ойлгох нь ариун сүмийн шүтээнийг, сайн мэдээний нийт бүтцийн талаарх ой дуртгалыг сэргээхэд хамгийн үр ашигтай аргуудын нэг болгодог.

Ариун сүмийн ажлын үнэний талаарх дотоод хүчтэй нотолгооны хувьд өөр нэг зүйл ямагт миний сонирхлыг татдаг. Бошиглогч Иосеф Смитэд . . . Их Эзэнээр илчлэгдсэн индаумент болон ариун сүмийн ажил нь: Бэлтгэл ёслолууд; тайлбарлагчдаас өгөх заавар болон төлөөллүүд; гэрээнүүд; эцэст нь, мэдлэгийн сорилууд гэсэн дөрвөн тодорхой хэсэгт хуваагддаг. Учир шалтгааны ухаанд суралцаж боловсроогүй Бошиглогч Иосеф юмыг учир шалтгааны талаас нь өөрөө ийнхүү бүрэн төгс гаргаж чадсан гэдэгт би эргэлздэг. (John A. Widtsoe, "Temple Worship," *The Utah Genealogical and Historical Magazine* 12 [April 1921]: 58.)



Усан Баталгааны Сан, Вашингтон Д.С. Арцун Сүм

Ахлагч Видцоегийн өгүүллээс дахин иш татья:

Бид бэлэг тэмдгүүдийн ертөнцөд амьдардаг. Бэлэг тэмдгүүдгүйгээр бид юу ч мэдэхгүй. Бид хуудас цаасан дээр хэдэн тэмдэг тавиад түүнийгээ хайр, эсвэл үзэн ядалт, эсвэл энэрэл, эсвэл Бурхан буюу мөнх оршихуй гэсэн утгатай гэж хэлдэг. Тэдгээр тэмдгүүд харахад тийм ч аятайхан биш байж болно. Номын хуудсан дээрх бэлэг тэмдгүүдээс хэн ч согог дутагдлыг олж үл чадна, учир нь тэдгээр нь төлөөлж буй тэдгээр зүйлсийнхээ гоё сайхны адил тийм хүчирхэг биш юм. Б-у-р-х-а-н гэсэн бэлэг тэмдгээс бид асууж эс чадна, учир нь энэ нь тийм ч аятайхан биш, гэхдээ л Бурханы сүр жавхланг төлөөлдөг. Хэрэв зөвхөн бэлэг тэмдгүүдийн утга нь бидэнд тодоор ойлгогддог бол, бэлэг тэмдгүүдтэй байгаадаа бид баяртай байна. Би өнөө орой та нарт хандаж үг хэллээ; миний ярьж байгаа байдал буюу үг хэллэгийн сонголтын талаар та нар асуусангүй; учир нь та нарт ойлгуулах гэж хичээсэн миний санаа бодлуудын утгыг илэрхийлэх үг хэллэг хийгээд өнгө аясыг та нар мартсан байна. . . .

Бид бэлэг тэмдгүүдийн ертөнцөд амьдардаг. Эрэгтэй эмэгтэй хэн ч бай, утгыг нь бэлэг тэмдгүүд илэрхийлдэг тэр бодит хүчнийг бэлэг тэмдэггүйгээр хараад, индаумент хүртэн ариун сүмээс гарч явж эс чадна." ("Temple Worship," page 62.)

Хэрэв та ариун сүмд явбал, ойлголт тань өргөжин тэлж, мэдрэмж тань илүү өргөжин тэлж, тэрхүү сүнслэг зүйлүүдийн талаарх мэдлэг тань нэмэгдэнэ хэмээх зөв санаа бодолтойгоор эндээс гарч явахдаа сургаал нь бэлэг тэмдгийн шинжтэйг дурсан санах болно. Номлолын төлөвлөгөө нь жавхлан төгс юм. Энэ нь сүнсээр удирдагдсан бөлгөө. Их Эзэн, Эзэн Багш Өөрөө шавь нартаа заасан Өөрийн номлолдоо сургаалт үлгэрүүдээр, өөр аргаар заахад ойлгоход хэцүү зүйлүүдийг бэлэг тэмдгээр төлөөлүүлж ярих аргаар заадаг байлаа. Тэрээр шавь нарынхаа амьдралаас авсан нийтлэг жишээнүүдийн талаар ярьдаг байв; мөн Тэрээр эм тахиа болон дэгдээхийнүүд, шувуу, цэцэг, үнэг, мод, дээрэмчин тонуулчид, нар жаргалт, баячууд ба ядуус, домчид, нөхөөстэй хувцас, хогийн ургамлыг сугалж хаях, гэр шүүрдэн цэвэрлэх, гахай тэжээх, тариа цайруулах,

саравчинд агуулах, байшин барих, туслуулахаар хүн хөлслөх гэхчлэн бусад олон зүйлийн тухай ярьсан байдаг. Гичний үр, сувдны тухай Тэрээр ярьсан байдаг. Тэрээр сонсогчиддоо заахыг хүсэн энгийн юмнуудын талаар бэлэг тэмдгийн байдлаар ярьдаг байв. Эдгээр зүйлсийн аль нь ч учир битүүлэг буюу ойлгомжгүй юм биш, харин эд бүгдээрээ бэлэг тэмдгийн шинжтэй.

Ариун сүм өөрөө ч бэлэг тэмдэг. Хэрэв та ариун сүмүүдийн аль нэгийг шөнийн цагаар бүрэн гэрэлтүүлэгдсэн байхыг нь харвал, хичнээн сэтгэл татам дүр төрхтэйг мэдэх болно. Гэрэлд умбасан Их Эзэний өргөө түнэр харанхуйд сүндэрлэн, сүнсний харанхуй руу чиглэсэн дэлхийн гэрэлт цамхаг луга, Есүс Христийн сайн мэдээний хүч хийгээд сүнслэг урмын бэлэг тэмдэг болон сүндэрлэх бөлгөө.

Ариун сүмийн ёслолыг анхны тохиолдлоор бүрэн ойлгохгүй байж болно. Зөвхөн заримыг нь л ойлгох болно. Дахин дахин, эргэн эргэн очигтун. Сурахаар эргэн очигтун. Ухаж ойлгоход нэн төвөгтэй буюу хүнд хэцүү зүйлүүд мөн толгой эргүүлмээр буюу учир битүүлэг зүйлүүд нь танд танигдах болно. Тэдгээрийн ихэнх нь хэн нэгэн хүнд үнэхээр тайлбарлаж үл болох цэвэр хувь хүний шинжтэй зүйлүүд байх болно. Гэвч өөрийн тань хувьд бол тэдгээр нь мэддэг зүйлүүд байна.

Ариун сүмээс бидний мэдэж авах зүйл нь даруу байдал хийгээд хүндэтгэл бишрэлээр мөн сурах гэгээрэх хүслээр бид ариун сүм рүү юутай очих вэ гэдгээс ихээхэн хэмжээгээр шалтгаална. Хэрэв бид заалгаснаа ойлгох чадвартай аваас, ариун сүмд бидэнд Сүнсээр заах болно.

Ариун сүмд индаумент хүртэх хэсэгт оролцох юм уу, эсвэл холболтын гэрч болох завшаан танд тохиосон үед та өөрийн тань үзсэн зүйл таны өмнө юуг илтгэн харуулсны гүн гүнзгий утга учрыг тунгаан бодогтун. Ариун сүмд орсны дараах өдрүүдэд эдгээр зүйлсийн талаар эрэгцүүлэн бодогтун; нам гүм хийгээд залбиралтайгаар тэдгээрийг дахин цэгнэж үзвэл, мэдлэг тань өргөжин тэлэхийг та олж мэднэ.

Ариун сүмийн туршлагын агуу их нэг үнэ цэнэ бол энэ дэлхийд холбогдох Бурханы зорилгуудын бүхнийг хамарсан, өргөн цар хүрээг төлөөлдөг явдал мөн. Бид ариун

сүмд орсноороо (бид энд эргэн ирж, ой дуртгалаа дахин сэргээж болно) амьдралын үйл явдлууд нийт дүр төрхөөрөө илрэн харагддаг. Бид хаана байгаагаа, мөн бид хэзээ замаасаа тэр дорхноо гажиж болохыг тодоор харж чадна.

Иймээс ариун сүм өөд тэмүүл. Хүүхдүүдээ ариун сүм өөд удирдагтун. Бүр бага балчраас нь эхлэн тэдний анхаарлыг үүнд хандуулагтун, мөн ариун сүмд орох тэр өдөрт нь тэднийг бэлтгэж эхлэгтүн.

Түүний хажуугаар, өөртөө заах чадвартай байгтун, хүндэтгэл бишрэлтэй бай. Зөвхөн ариун сүмд байдаг тэрхүү сургаалуудаас, бэлэг тэмдгийн, гүн гүнзгий сүнслэг сургаалуудыг дуртайяа хүлээн авч, гүнзгийгээр бясалгагтун.

Ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэх нь цаг хугацаа шаарддаг. Үүнд анхааралтайгаар төлөвлөвөл зохино. Хайр сэтгэлтэй болсон залуу хосууд эцэг эхийнхээ гуйлтыг эс хайхран тэр дорхноо, ганц хоёрхон долоо хоногийн дараа гэрлэхээр шийдэж, шалан шаардах нь олонтаа тохиолддог. Бэлтгэхэд илүү хугацаа шаардагдах тухай эцэг эхийнхээ хүсэлтийг залуу хосууд заримдаа өөрсдийнх нь гэрлэлтийг эцэг эхчүүд нь сайшаахгүй байна гэж үзэх нь ч байдаг. Хэрэв хүлээх юм бол тэдний гэрлэлтэд ямар нэг зүйл саад учруулж болно гэж залуу хосууд айдаг. Зарим залуу хосууд гэрлэлтээ түргэн зохион байгуулахаар шахаж шаардах нь үүнийг зөвхөн их бэрхшээл хийгээд ямар нэг өөр нөхцөл байдал нөлөөлсөн юм шиг дурсан санах юмаар багахан байхад хүргэж, тэд өөрсдийгөө өсч төлөвшөөгүй, эелдэг бус болохыг харуулдаг.

Хэрэв хэт яарч, хэт шахалтанд орвол, ариун сүмийн анхны аялалаас, эсвэл ариун сүм дэх хуримнаас ямар нэг зүйл орхигдож болно. Ийнхүү ариун сүмд анх удаагаа орох буюу хуримынхаа өдөр холболт хийлгэх нь амьдралд зөвхөн ганц удаа л тохиодог зүйл мөн. Үүнд бэлтгэх ёстой. Энэ бол бэлтгэлд нь жижиг сажиг зүйлсийг ч, гэр ахуйн аар саар зүйлийг ч гэсэн үүнээс салган орхиж үл болох тийм их ач холбогдолтой зүйл. Энэ шалтгааны улмаас юм бүхнийг өмнөөс хийх ёстой. Зарим нэг нэн чухал зүйлийг тэр өдрийг хүртэл хийгээгүй байх нь туйлын сэтгэл гонсойлгомоор зүйл байж болох юм.

Хэрэв та цуглаанд эрт ирж, шүтээний байранд чимээгүйхэн сууж, ирж байгаа хүмүүсийг ажиглах юм бол, тэд

ямар нэг юм авчирч байгааг та харах болно. Сүнслэг уур амьсгал бүлээсч, урам зоригтой ах, эгч нар болох цугла-рагсдаар хоосон өрөө дүүрч өөрчлөгдөнө.

Эдүгээ, бид зав чөлөөгүй үедээ хурал цуглаанд явахдаа үүнийг дандаа хийж чаддаггүй. Хурал цуглаанд хандах энэ хандлага бидэнд юу өгөх нь, ариун сүмд явахад энэ нь хоёр дахин ач холбогдолтой. Ялангуяа энэ нь анх удаа явж байгаа үед бүр ч чухал юм. Бид тийшээ эрт явах ёстой.

Ийнхүү эрт явах нь зөвхөн хамгаалалт төдийгүй, харин зөвшөөрлийн бичиг хийгээд бусад зүйлүүд зохих жур-маараа байж, бид өөрсдийгөө шинэ мэдрэмжинд дасгад-гийг та харж байна. Энэ нь үүнээс ч илүү. Энэ нь зөв сүнсэнд тайвнаар орохын тулд болох гэж буй зүйлд өөрс-дийгөө бэлтгэхийн тулд орох ёстой газартаа цагт нь орох явдал юм.

Бид ариун сүмийн туршлагад оролцогчдын хувиар яри-лаа, гэвч зарим үед ариун сүмийн хурим төлөвлөгдөхөд гэр бүлийн нэн ойр дотнын зарим гишүүд ариун сүмийн зөвшөөрлийн бичгийн шаардлагыг хангахгүй явдал то-хиолддог. Энэ нь хүргэн буюу бэр нь шинэ гишүүн бөгөөд эцэг эх нь Сүмд хараахан ороогүй эсвэл тэд ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах болоогүй Сүмийн шинэ гишүүд байж болно. Эсвэл эцэг эх нь Сүмийн гишүүд атал тэдний нэг нь ариун сүмийн зөвшөөрлийн бичиг хүлээн авахуй-цаар сайн мэдээний жишгүүдийн дагуу амьдардаггүй байж болно. Эдгээр хязгаарлалтууд ариун сүмийн гэрлэлтийн үед том асуудлууд байдаг. Ийм үе нь гэр бүлүүд нэн ойр дотно байж, амьдралынхаа эдгээр ариун нандин мөчүүдэд хамтдаа байж хуваалцах ёстой. Ариун сүмийн зөвшөөр-лийн бичгийн шаардлагыг хангахгүй хүнд түүнийг өгөх-гүй байх буюу гишүүн биш найз буюу садан хамаатнаа холболтын гэрчээр урьж чадахгүй байх нь асуудлыг хур-цатгаж болно. Энэ нь туйлын амгалан тайван байж, дээд зэргийн эвсэг байвал зохих яг тэр мөчийг баяр хөөргүй болгож, зөрчил сөргөлдөөнд хүргэж болно.

Энэ мэтийн тохиолдлуудад бид яах вэ? Бишопт ша-халт үзүүлэх нь бидний хийж болохгүй зүйл юм. Тогтсон жишгээр бол Израилын олон нийтийн шүүгч байх үүр-гийг хүлээдэг бишоп, шаардлага хангаагүй хэн нэгэнд ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олгох нь шударга бус





Бүтээлтийн Өрөө, Солт Лэйкийн Арцун Сүм

хэрэг болно. Ингэх нь үүнд оролцогч хувь хүмүүсийн хувьд туйлын зохисгүй буруу үйлчлэл болно. Түүнчлэн бишопын өөрийнх нь хувьд ч энэ нь шударга бус явдал болно.

Ариун сүмийн гэрлэлтийг товлочихсон ба эцэг эхийнх нь аль нэг нь буюу нэн ойрын төрөл садан нь ариун сүмд орох боломжгүй үед нэн ул суурьтай төлөвлөлт нь асуудлын оронд сайхан боломжийг олгоно. Эдгээр зөвлөмжүүдийг анхааралтай авч үзэгтүн. Гишүүн бус эцэг эх, эсвэл ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авах шаардлагыг хангаагүй гишүүнийг ариун сүм дэх хуриманд урь. Ариун сүмийн талбайд өөр хаана ч байдаггүй сүнс хийгээд нөлөө байдаг. Зарим ариун сүмүүдэд айлчлагчдын төв байдаг. Ямар ч тохиолдолд ариун сүмийн талбайг үзэсгэлэнтэй сайхнаар байлгадаг. Ариун сүм хийгээд түүний газар дахь бүх зүйл нь амар амгалан ба нам гүм байдлыг илэрхийлдэг.

Гэр бүлийн тэр гишүүнтэй цуг хүлээх хэн нэгнийг томил. Юутай ч гэсэн та тэр хүнийг ганцааранг нь орхих учиргүй. Ариун сүмд орох эрхтэй гэр бүлийн гишүүд нь гэрлэлтийн гэрч болохынхоо оронд гэрлэлтэд оролцох боломжгүй хүмүүстэй ариун сүмийн талбайд байхдаа илүү сэтгэл ханамжтай байдгийг олон жишээ харуулдаг. Ариун сүмийн эргэн тойронд тэд Их Эзэний өргөөнд холболт хийлгэх залуу хосуудын хүслийг тайлбарлах боломжтой болдог.

Энэ үед өөр ямар ч байдлаар олдох боломжгүй агуу их нөлөөллийг мэдэрч болно. Жишээ нь, ариун сүмүүдийн зарим томоохон тойрон аялалууд танилцуулагддаг. Урьдаас төлөвлөх нь ямар нэг шалтгааны улмаас ариун сүмд орох боломжгүй гэр бүлийн нэн ойрын гишүүний эрэл хүсэлтийг тусгайлан анхаарч, шийдвэрлэх боломж олгож болох юм. Гишүүн бус эсвэл ариун сүмд орох эрхгүй эцэг эхчүүдэд тохиолддог урам хугаралт, бүр дургүйцэл, зарим үе дэх гашуун сургамжийг ийм арга замаар үлэмж хэмжээгээр зөөлрүүлж болно.

Зарим ариун сүмүүдэд ариун сүмд орох эрхгүй эцэг эхчүүдийнх нь асуултуудад хариулж чадах мэргэшсэн хүнтэй уулзах тусгай өрөө байдаг.

Эцэг эхчүүд нь бэр болон хүргэний бүх амьдралын туршид хуримыг нь хүлээж байсан байж болно гэдгийг

залуу хосууд ойлгох ёстой. Хуриманд оролцох тэдний хүсэл, ингэж чадахгүй тохиолдолд тэд дургүйцэх нь эцэг эхийн ойр дотно харилцааны илрэл юм. Энэ бол залуу хосуудын хувьд дургүйцэх зүйл биш. Үүнийг ойголцож, хуримын нэг хэсэг болгон анхааралтайгаар төлөвлөх хэрэгтэй.


Ариун сүмд орох боломжгүй эцэг гомдох буюу тайвшрахгүй байж болох хэд хэдэн тохиолдол байдаг. Ийм тохиолдолд залуу хосууд нөхцөл байдалд зохицож, хамгийн зөв шийдвэр гаргах хэрэгтэй. Энд ийм асуулт тулгарч болно: За тэгвэл бид эцэг эх маань гэрлэлтийн гэрч байж чадах иргэний журмаар гэрлээд дараа нь ариун сүмд орохын өмнө шаардлагатай тэр жилийг хүлээх үү? Гэвч энэ бол төгс сайн шийдвэр биш. Залбирч, анхааралтайгаар төлөвлөх нь олонх тохиолдолд бэрхшээлтэй асуудлыг, гэр бүлийг урьд өмнө байснаас нь бүр ч илүүгээр ойртон нягтруулах аятай сайхан боломж болгон хувиргадаг байна.

Гэрлэлтийн гэрчээр хэт олон найз, хэсгийн гишүүд гэх мэт хүмүүсийг урих хэрэггүй. Хуримд уригдагсад нь ихэвчлэн хоёр талын гэр бүлийн гишүүд, хосын нэн ойр дотнын цөөхөн хүнээс бүрдсэн цөөн тоотой байх ёстой. Хуриманд бүгдийг урин хэсэгт зарласан тохиолдолд гэрлэж байгаа хосуудыг урамшуулан дэмжихийн тулд бүгдээрээ оролцохыг хичээх хэрэгтэй. Үүний тулд л хүлээн авалтыг хийдэг юм. Хуримын хүлээн авалт нь найз нөхөд хийгээд баяр хүргэгчдэд баяр хүргэх цаг гаргаж өгдөг. Ариун сүмийн гэрлэлт ариун нандин байх ёстой бөгөөд хуримлаж байгаа хосын амьдралд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг зөвхөн тэр хүмүүс л үүнийг хуваалцах ёстой.

Бид холболтын ёслолын үгсийг ариун сүмээс гадуур хэлэх ёсгүй, гэвч холболтын өрөөний гоё сайхныг, сүнслэг байдлын хувьд нам гүм, амар тайван байдлыг нь, мөн тэнд хийгддэг ариун нандин ажлын тухай ярьж болно.

Хосууд холбох ёслол хийлгэхээр тахилын ширээнд хүрч очихын өмнө, албан хаагч залуу хосуудад зарим зөвлөгөө өгөх нь, мөн залуу хосууд хүлээн авах нь сайхан боломж юм. Эдгээрт энэ үед залуу хосын сонсвол зохих зүйлс багтдаг билээ.

“Өнөөдөр та нарын хуримын өдөр. Гэрлэлт тань та нарын сэтгэлийг догдлуулж байгаа. Энэ мэт ёслолуудын



*Цэцэрлэгийн Өрөөнөөс Харагдах Байдал, Калифорни Лос Анжелесийн  
Ариун Сүм*

ариун нандин газар болон ариун сүмүүд нь баригдсан. Энд бид дэлхийд байгаа биш юм. Дэлхийн зүйлүүд энд байдаггүй бөгөөд бидний энд хийх зүйлд нөлөө үзүүлэх ёсгүй. Бид дэлхийгээс гарч Их Эзэний ариун сүмд орж ирээд байна. Энэ нь та нарын амьдралын хамгийн чухал өдөр болдог.

“Та нарын сүнс оршин байхад зориулсан мөнх бус байдлын табернеклийг бэлтгэсэн эцэг эхчүүдээрээ та нар уригдан энд төрсөн билээ. Та хоёр хоёулаа усаар батлуулсан байгаа. Ариун нандин ёслол болох усан баталгаа нь цэвэршилтийн бэлэг тэмдэг, үхэл ба дахин амилалтын бэлэг тэмдэг, шинэ амийн дотор явахын бэлэг тэмдэг юм. Наманчлал ба нүглээс ангижрах нь үүнд багтдаг. Ариун ёслол бол усан баталгааны гэрээний шинэчлэл мөн, хэрэв бид үүнийг амьдралдаа баримталбал бид нүглээсээ ангижирч чадна.

“Хүргэн та санваарт томилогдсон. Та эхлээд Аароны Санваар хүртэж, түүний бүх албан тушаалууд: дикон, багш, санваартныг дамжин шат ахисан байх. Дараа нь танд Мелкизедек Санваар хүртэхүйц зохистой болсон тэр өдөр ирсэн байгаа. Санваарын дээд болох энэ санваар нь Бурханы хамгаас ариун журам болох Бурханы Хүүгийн Журам Ариун Санваар хэмээн тодорхойлогддог буюу. (Алма 13:18 болон Хиламан 8:18-ыг үз.) Танд санваарын нэг албан тушаал өгсөн байгаа. Эдүгээ та ахлагч.

“Та хоёрын аль аль нь индаументаа хүртсэн байгаа. Энэ индаументэд та хоёр мөнхийн боломжийг олсон байгаа. Гэвч эдгээр бүх зүйлүүд нь нэг талаар та хоёр энэ амьдралд болон мөнхөд эхнэр нөхөр болон холбогдохоор тахилын ширээнд ирэхийн өмнөх угтвар бэлтгэл болсон билээ. Эдүгээ та хоёр амьдралын бүтээлтэд чөлөөтэй ажиллаж, дэлхийд хүүхдүүд авчран, тэднийг өсгөн өндийлгөж, мөнх бус байдлын туршлагаар дамжуулан тэднийг аюулгүй байхад нь туслахад өөрсдийгөө зориулж, золиос хийх; нэгэн цагт өөрсдийнхөө адил ариун сүмийн эдгээр ариун нандин ёслолуудад тэдний оролцохыг нь харах гэр бүл боллоо.

“Та хоёр энд сайн дураараа ирсэн бөгөөд зохистой гэж үнэлэгдсэн болно. Энэхүү холбоо нь Амлалтын Ариун Сүнсээр холбогдох болно.”

Их Эзэн өөрийн найз нар болох бидэнд, бидний зүрх сэтгэлд оршин байх өөр нэг Тайтгаруулагчийг бидэнд илгээнэ хэмээн хэлжээ. Энэ Тайтгаруулагч бол Амлалтын Ариун Сүнс юм. Шавь нартаа түүний амласан өөр Тайтгаруулагчийн тухай Иоханы гэрчлэлд тэмдэглэгдсэн байдаг.

Энэ Тайтгаруулагч нь мөнх амьдралын тухай, бүр сэлэсчел хаант улсын алдрын тухай Их Эзэнээс бидэнд өгдөг амлалт юм. (С ба Г 88:3–4.)

“Бие биендээ гэрлэлтийн гэрээг хүлээн зөвшөөрнө гэдэг нь хэмжээлшгүй их адис ивээлийг авчрагч асар их хариуцлага юм.”

Хүргэн бэр хоёр хуриманд маш их сэтгэл хөдлөн холбох ёслолын үгсийг анхааралтай сонсохгүй буюу ерөөсөө сонсохгүй ч байж болно. Эдгээр үгсийг бид ариун сүмээс гадуур давтаж болохгүй болохоор хуримд гэрч болон эргэж очиж болно. Үүнийг хийх эрх мэдлийг бидэнд олгосон Их Эзэн өгөөмөр ажээ. Эдгээр үйл явдлуудын үеэр бид биечлэн хамрагдаагүй тохиолдолд ёслолын үгсийг анхааралтай сонсох хэрэгтэй. Мэдээж хэрэг үүний адил нас барагсдыг төлөөлөхөөр бид энд ойр ойрхон эргэж ирснээр индаументийн талаарх бодол санаа хийгээд сүнслэг байдлаа сэргээн шинэчилж чадна.

Хэрэв та иргэний ёслолоор өмнө нь гэрлэсэн бол та одоо мөнхийн холболт хийлгэхийг хүсч болно, тэрчлэн, хэрэв та хүүхдүүдтэй бол, тэднийг мөнхийн гэр бүлд өөрсөдтэйгөө холбуулж болно. Хэрэв та үүнийг хүлээн авах шаардлагыг хангах юм бол энэ нь уг адислалыг хүлээн авах таны агуу онцгой эрх байх болно.

## *ЦАГААН ӨНГИЙН ХУВЦАС ӨМСӨХ*

Бид ариун сүмд ёслолын ажил гүйцэтгэхдээ цагаан өнгийн хувцас өмсдөг. Энэ хувцас нь цэвэр ариун, зохистой байдал, ариун журмын бэлэг тэмдэг юм.

Та ариун сүмд ормогцоо байнга өмсдөг хувцсаа ариун сүмийн цагаан хувцсаар сольж өмсдөг. Хувь хүн болгонд зориулсан цоожтой шүүгээ бүхий, нэг хүнд тохирсон зайтай жижиг өрөөнд зөвхөн ганцаараа хувцсаа сольдог. Ариун сүмд төгс даруу байдлыг анхааралтайгаар сахин

баримталдаг. Та өмсөж ирсэн хувцсаа цоожтой өрөөнд орхисноороо өөрийнхөө анхаарч санаа тавьдаг зүйлүүд, зугаа цэнгэлийг тэнд үлдээлээ гэсэн үг. Чи энэ ганцаарчилсан жижиг хувцас солих өрөөнөөс бүхэлдээ цав цагаан хувцас өмч гарч ирдэг бөгөөд чамтай адил хувцасласан чиний эргэн тойрон байгаа хүмүүстэй адил тэгш хийгээд тэдний нэг гэсэн мэдрэмжтэй байдаг.

Хэрэв та ариун сүмд анх удаагаа явж байгаа бол бишоптгойгоо зөвлө. Тэрээр танд ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олгохдоо ариун сүмд шаардагдах хувцаслалтын талаар ямар нэг зүйл тайлбарлаж өгөх болно. Энэ хувцсыг олж авах тухайд та санаа зовсны хэрэггүй. Та үүнийг Сүмийн Хангамжийн Үйлчлэлүүдээр дамжуулан худалдаж авах эсвэл зарим тохиолдолд, ариун сүмд түрээсээр авч болно. Хувцсыг түрээсээр авсан тохиолдолд зөвхөн угаалгын үнийг л багтаасан тун бага хөлс төлөх шаардлагатай болдог. Хувцас түрээслэх нь жижиг ариун сүмүүдэд байдаггүй.

Ариун сүмийн ёс жаягууд хийгээд ёслолуудын үед сүмийн дотор өмсдөг хувцасны талаар бид ариун сүмээс гадуур туйлын бага ярьдаг. Энэ бол ёслолуудынхаа адил туйлын их бэлэгдлийн утгатай гэдгийг бид хэлж болно.

Сүмийн гишүүн ариун сүмд ороод Их Эзэний дэргэд эвгүйцэхгүйн тулд биеэ тусгайлан бэлтгэж, сайхан хувцасласан байх нь хүндэтгэл бишрэлийн шинж тэмдэг мөн. Ихэд нэрд гарсан гүн хүндэтгэл хүлээдэг нэгэн удирдагчийн гэрт өөрийгөө зочноор түр уригдлаа гэж төсөөлөн бодоод үз. Мөн нэг адил ийм урилга хүлээн авсан алдар хүндтэй зочдын дунд та өөрийгөө орно гэж ойлгох эсвэл ингэж бодох ёстойг зөвлөжээ. Урилга нь гэрийн эзэн таныг гүнээ хүндэтгэдгийг харуулж байна. Гэвч өөр олон хүмүүс ийм урилга хүлээн авах гавьяатай ч гэсэн ямар нэг шалтгааны улмаас ийнхүү уригдах боломжгүйгээс ирж чадахгүй байгаа юм гэдгийг та мэдлээ. Ийм нөхцөл байдалд таныг элэгдсэн хуучин хувцастай эсвэл амарч яваа юм шиг хувцасласан байна гэдэг нь эргэлзээтэй хэрэг. Эрэгтэй хүн сахлаа хусаагүй эсвэл эмэгтэй хүн үсээ засч янзлаагүй ирнэ гэдэг нь эргэлзээтэй хэрэг юм.

Нэр төр хийгээд сайн сайхан байдлыг эрхэмлэдэг хүмүүс чухал цугларалтын урилга хүлээн авсныхаа дараа ямар хувцас үүнд тохирох вэ гэдгийг ямагт асуудаг. Ийм

онцгой үйл явдалд та нэн анхааралтайгаар бэлтгэхгүй гэж үү? Гадаад төрх байдал чинь эрхэм дээд хүндэтгэлтэй байдлыг бууруулахгүйн төлөө итгэл найдвараар та бүр шинэ хувцас худалдан авч болно.

Мөн хувцсаа индүүдэж, цэвэрлэсэн байхад анхаарал тавих хэрэгтэй. Хэрэв та зохих ёсоор хувцаслаагүй бол танд эвгүй байх болно.

Ариун сүмд очих боломжийг ийм урилгатай харьцуулж болно.

Сүмийн гишүүд “ердийн” хувцастайгаар ариун сүмд орж болдог нэг л тохиолдол бий, энэ бол тэд ариун сүмийн гэрлэлтийн гэрч болох үе юм. Энэ тохиолдолд зөвхөн гутлаа тайлж оронд нь цагаан өнгийн шаахай өмсөж болно. Хэдэн жилийн өмнөөс Ах нар гэрлэлтийн яг өмнөх индаументийн хэсэгт орохгүй тэдгээр гэр бүлийн гишүүд болон найзууд нь ийн байх зөвшөөрөл олгожээ.

Хүргэн, бэрүүд энэ амьдралдаа болон үүрд мөнхөд гэрлэхээр ариун сүмд ордог. Энд бэрүүд даруу загвартай, мяндсан утсан, урт ханцуйтай, чамин хээ угалзгүй цагаан даашинз өмсдөг. Хүргэнүүд бас цагаан хувцастай байдаг. Ариун сүмийн гэрлэлтэд гэрчээр ирж байгаа ах нар хуримын хантаазан хүрэм өмссөн байх ёсгүй.

Зарим үед бид ариун сүмд орох үедээ ариун сүмийн хэсэгт оролцож буй, эсвэл гэрлэлтийн гэрч зарим хүмүүс зугаалгаар явж байгаа эсвэл спортын байдлаар хувцасласныг хараад гайхаж, бас бага зэрэг харамсал төрдөг.

Ариун сүмд орох онцгой эрх нь үүнээс илүү ихийг биднээс шаарддаг билээ. Бид биеэ угааж, цэвэрхэн хувцаслах нь, хэдийгээр уг хувцас хямдхан ч гэсэн, Их Эзэнийг баярлуулдаг. Бид ариун ёслолын цуглаан эсвэл зохих ёсоор хүндэтгэлтэй хандвал зохих аль нэг цуглалалтад оролцоходоо ая тухтай байхын тулд иймэрхүү хувцаслах ёстой.

Зарим тохиолдолд хуримын гэрчээр ирсэн хэн нэг нь Ах нар хэрхэн хувцаславал зохих талаар өгсөн зөвлөгөөг бага анхаарч, даруу биш буюу зохимжгүй байдлаар хувцаслагчдын жишээг дагаж, үсээ урт ургуулж, уртаар засч янзалсан гэх мэт тохиолдлууд байдаг. Дэлхийн маягийг дагах явдлыг илэрхий эрхэмлэдэг хүмүүст Их Эзэн баяртай байдаггүйг мэдсээр байж, яагаад ийм хүнийг ариун сүмд оруулахаар зөвшөөрдөгт бид гайхдаг.





*Тэрэстрел Өрөө, Со.т Лэйкийн Арцун Сүм*

Даруу бус буюу дэлхийн байдлаар хувцасласан, ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй гишүүн ариун сүмд яаж орох юм бэ? Цэвэр цэмцгэр, журамтай байдалтай үл нийцэх байдлаар хүн үсээ засуулж яахан чадах билээ?

Ариун сүмийн ёслолуудад оролцох эсвэл холболтын гэрч болохоор ариун сүмд орох боломж олдсон үедээ та хаана байгаагаа санаж явагтун. Та бол Их Эзэний өргөөн дэх зочин билээ. Та Гэрийн Эзэнийг гарч ирэхэд сэтгэл санаа сайхан байхын тулд үс зүсээ янзалж сайхан хувцасласан байх ёстой.

Пристийн зэргийн адислалуудыг хүртэж, хуваалцдаг хүмүүс, индаументийн ёслолыг түүнд өгөх үеэр Бошиглогч Иосеф Смитэд илэрхийлэгдсэн тэр байдлаар тэд хувцасласан байх ёстой.

Ариун сүмийн ёслолуудыг хүлээж авсан гишүүд энэ цаг мөчөөс хойш тусгай гармент буюу дотуур хувцас өмсдөг. Сүмийн байгууллага эдгээр гарментыг хангадаг бөгөөд Сүмээс хэрэгжүүлдэг хангамжийн хөтөлбөрөөр дамжуулан дэлхий даяарх гишүүд үүнийг олж авч болно.

Гармент нь ариун гэрээнүүдийг төлөөлдөг. Энэ нь даруу төлөв байдлыг хөхүүлэн дэмждэг бөгөөд өмсөгчийнхөө бамбай ба хамгаалалт болдог.

Ийм гармент өмсөх нь дэлхийн улс үндэстнүүдэд нийтлэг өмсдөг шинэ загварын хувцас өмсөхөөс гишүүдийг түдгэлзүүлнэ гэсэн хэрэг биш. Зөвхөн даруу биш буюу хэт гажууд загварын хувцаслалт нь гарменттай үл нийцнэ. Ариун сүмд орсон ч байна уу, ороогүй ч байна уу ялгаагүй, Сүмийн аль ч гишүүн хэт гажууд буюу даруу биш загвараас зайлсхийхийг зохих сүнслэг байдалд хүсэх учиртай.

Индаумент хүртсэн сүмийн гишүүд гарментын талаар асуудалтай тулгарах явдал заримдаа байдаг.

Нэгэн үйл явдлын үеэр нэг ах Ньюпортын Роде Арал дахь Тэнгисийн Цэргийн Шашны Ажилтны Мэргэжлийн Сургуулийн факультет болон ажилтнуудад үг хэлэхээр уригджээ. Сонсогчдын дунд Католик, Протестант болон Жүүдийн итгэл бишрэл бүхий тэнгисийн цэргийн өндөр албан тушаалын нилээд хэдэн шашны ажилтан байв.

Асуулт хариултын үеэр шашны ажилтнуудын нэг нь, “Та Мормоны тусгай үйлчлэл хийлгэсэн зарим хүмүүсийн өмсдөг дотуур хувцасны тухай бидэнд ямар нэг зүйл

ярьж өгөхгүй юү?” гэж асуув. Энэ асуултын далд санаа нь, “Та нар яагаад ингэдэг юм бэ? Энэ чинь хачирхалтай биш үү? Энэ чинь л асуудал бий болгож байгаа юм биш үү?” гэсэн хэрэг байлаа.

Асуулт тавьсан шашны ажилтанд тэрээр: “Та аль сүмийг төлөөлдөг вэ?” гэсэн асуултаар хариулав. Хариуд нь тэрээр Протестант сүмүүдийн нэгийг нэрлэв.

“Иргэний амьдралд, мөн түүнчлэн цэргийн албан хаагчдад үйлчлэл үзүүлэх цуглаанууд явуулахдаа та нар мөн шашны тусгай хувцас өмсдөг биз дээ, тийм үү?” хэмээн хэлэхэд нөгөөх шашны ажилтан тэгдэг ээ гэж хариулав.

Тэрээр цааш нь үргэлжлүүлэн: “Энэ нь та нарын хувьд зарим нэг ач холбогдолтой бөгөөд та нарыг танай хүмүүсийн үлдсэн хэсгээс ямар нэг байдлаар заагладаг гэж би боддог. Үүнийг үйлчлэлд та нарын өмсдөг дүрэмт хувцас гэж нэрлэж болмоор санагддаг. Түүнчлэн, үүнийг би чухал ач холбогдолтой зүйл гэж бодно. Энэ нь та нар хэн болох хийгээд мөн та нарын үүргүүд бас гэрээнүүд юу болохыг та нарт сануулдаг билээ. Энэ нь, та нар бол тэр сүмийн гишүүд, та нар өөрсдийгөө Их Эзэний үйлчлэгчид гэж үздэгийн, мөн та нар өөрсдийнхөө томиллолтод зохистой байхын тулд ийм замаар амьдрах хариуцлага хүлээсний байнгын сануулагч юм.”

Дараа нь тэрээр тэдэнд: “Хожмын үеийн Гэгээнтнүүд бид яагаад гарментэд сүнслэг талаараа гүн гүнзгий хүндэтгэлтэй ханддагийн дор хаяж л нэг шалтгааныг та нар ойлгох учиртай. Танай болон манай сүмийн хоорондох гол ялгаа нь гэвэл та нарт байдгийн адилаар бидэнд шашны мэргэжлийн ажилтан байдаггүй. Цугларагсад бүгдээрээ орон нутгийн удирдагчдаар тэргүүлүүлдэг. Тэд янз бүрийн ажил мэргэжлийн хүмүүсээс дуудагддаг. Харин тэд пристийн зэрэгт томилогддог билээ. Тэд пристийн зэргийн албан тушаалуудад ажилладаг. Тэд ерөнхийлөгчид, зөвлөхүүд болон янз бүрийн удирдагчдаар онцгойлон адислагдаж, томилогддог. Мөн эмэгтэйчүүд ч гэсэн эдгээр үүрэг хариуцлагуудаас хуваалцдаг. Ням гарагт болдог манай цуглааныг тэргүүлэгч бишоп нь Даваа гарагт шуудангийн ажилтан, албан хаагч, фермийн аж ахуйтан, эмчийнхээ ажилд явдаг; эсвэл тэр нисэх хүчний



*Сэлэсчел Өрөө, Вашингтоны Коламбиа Ривэр Ариун Сүм*

нисгэгч буюу усан цэргийн офицер байж болох юм. Бидний жишиг ойлголтоор бишоп бол танай жишиг ойлголтод байдгийн адил жирийн л нэг томилогдсон үйлчлэгч юм. Тэрээр ихэнх засгийн газруудаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Та нар өөрийнхөө шашны хувцаснаас ямар зүйлийг хүсэн хүлээдэг бол мөн тийм ашиг тусыг энэхүү тусгай хувцаснаас бид хүсэн хүлээдэг билээ. Ялгаа нь гэвэл бид уг хувцсыг гадуураа биш харин хувцсан дотуур өмсдөг, учир нь бид Сүм дэх өөрсдийнхөө үйлчлэлээс гадна янз бүрийн ажил мэргэжлээр ажилладаг. Эдгээр ариун нандин зүйлүүдийг бид дэлхийд үзүүлэхийг үл хүсдэг билээ” хэмээн ярилаа.

Дараа нь тэрээр, гарментыг өмсөх болон ариун сүмд хийдэг гэрээнүүдтэй холбоо бүхий зарим гүн гүнзгий сүнслэг учир холбогдлыг тэдэнд тайлбарлахдаа эдгээр нь нууц биш, харин ариун нандин учраас бид энд шүүн хэлэлцэх шаардлагагүй гэж тэрээр давтан хэллээ.

Бидний биеийг халхлагч энэхүү гармент нь эдгээр гэрээнүүдийн, нүдэнд харагдахуйц, бодит сануулагч болдог. Сүмийн олон гишүүний хувьд гармент нь түүнийг өмсөгч уруу таталттай учирсан үед хамгаалах халхавч болдог билээ. Энэ нь бусад зүйлсийн дотор Бурханы хуулиудад түүний дотор ёс суртахууны жишигт гүнээ хүндэтгэлтэй хандахыг бэлэгдэн харуулдаг.

## *ХОЛБОЛТЫН ХҮЧ*

Хэрэв бид ариун сүмийн ажлын түүх хийгээд номлол аль алиныг нь ойлгохыг хүсэх аваас холболтын хүч гэж юу болохыг бид ойлгох учиртай. Хамгийн багаар бодоход яагаад холболтыг хэрэглэх эрх мэдлийн түлхүүрүүд нь шийдвэрлэгч ач холбогдолтой байдгийг бид төсөөлөх ёстой.

Христээс өмнө бараг есөн зуун жилийн өмнө Бошиглогч Элайжа Израилын хааны шүүхэд дуудагдан иржээ. Тэрээр ариун нандин эрх мэдэл болох холболтын хүчийг өөртэйгөө хамт авчирсан байв.

Элайжа өөрийн тохинууллыг боловсруулж, өөрийгөө залгамжлуулахаар Элишаг тохоон томилж, тэгээд мөн энэ нь чухал байснаас тэрээр үхсэнгүй. Өөрийн өмнөх Мосегийн адил, тэрээр зөөгдөн аваачигджээ.

Үүний дараа, түүний нэр Хуучин Гэрээнд, Хуучин Гэрээний сүүлчийн бүлгийн сүүлчийн шүлгийн өмнөх шүлэгт зөвхөн ганцхан удаа гардаг. Элайжа эргэн ирж, тэрээр “эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүү нь, мөн хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эцгүүд рүү нь эргүүлэх болно”, эс бөгөөс бүхэл газар дэлхий зүхлээр арчигдсан байх болно хэмээн Малахи бошиглосон байдаг. (Малахи 4:5–6-г үз.)

Есүс Христ Цезарийн Филиппийн нутагт очсон үедээ шавь нараасаа, хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна вэ? гэж асуув.

Тэгэхэд тэд, Зарим нь таныг Иохан Баптист гэдэг; зарим нь Елиа; харин зарим нь Иеремиа эсвэл бошиглогчдын нэг гэж ярьдаг, гэхэд

Тэр, Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ? гэсэнд

Симон Петр хариулан, Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн гэв.

Есүс түүнд хариулан, Бариона Симон оо, чи ерөөлтэй еэ. Учир нь үүнийг чамд мах цус нь биш харин тэнгэр дэх миний Эцэг илчилсэн юм гэв.

Би мөн чамд хэлье. Чи бол Петр. Энэ хадан дээр би өөрийн сүмээ босгох бөгөөд түүнийг үхэгсдийн орны хаалга дийлэхгүй.

Мөн би чамд тэнгэрийн хаант улсын түлхүүрүүдийг өгнө; чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно: газар дээр чи юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно гэжээ. (Матай 16:13–19.)

Петр, Иаков, Иохан нар Их Эзэний хамт Өөрчлөлтийн Уул уруу очиход, өөрчлөгдсөн Их Эзэнтэй хамт хоёр хүн үзэгджээ. Тэр хоёр хүн бол холболтын хүчийг тэрхүү ерөнхийлөгчийн зөвлөлд шилжүүлэн өгөхөөр ирсэн Мосе, Елиа нар болохыг тэд таньсан ажээ. (Матай 17:1–8-ыг үз; *Элиас* нь Елиа хэмээх еврей нэрний грек орчуулга бөгөөд Шинэ Гэрээнд, Хуучин Гэрээний бошиглогч Елиаг заахад олонтаа хэрэглэгддэг.)

Петр түлхүүрүүдийг атгадаг байв. Газар дээр холбох буюу газар дээр тайлах нь мөн тэнгэрт ч нэгэн адил байх тэрхүү хүчийг агуулагч эрх мэдэл, холболтын хүчийг Петр атгаж байлаа.

Түүнийг цовдолсны дараа, МЭ 34 онд, Их Эзэн Нифайчуудад тохинуулж байв. Тэрээр тэдэнд хэлж өгч байсан бөгөөд энэ нь судрын түүхэнд Малахийн сүүлчийн хоёр бүлэг нь (Елиа эргэж ирэх тухай бошиглолыг агуулсан) гайхамшигтай бөгөөд эдгээрийг бичиж авахад тэднийг хүргэж, тэгээд дараа нь тэдгээрийг тайлбарлажээ.

Тэнгэр элч Моронай ялтсуудын тухай ярихаар Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирэхдээ Елиа эргэж ирэх тухай Малахийн бошиглолыг иш татжээ. Энэ ишлэл нь эдүгээ Сургаал ба Гэрээний хоёрдугаар хэсэг болно.

Моронайг ирснээс хойш арван гурван жилийн дараа зорилгодоо дүйхүйц ариун сүм баригдсан бөгөөд Их Эзэн дахин хүрч ирэхдээ Елиатай хамт ирж холболтын хүчний түлхүүрүүдийг өгчээ.

Эдгээр түлхүүрүүд Сүмийн Ерөнхийлөгч, бошиглогч, үзмэрч, түүнчлэн илчлэгчид харьяалагддаг билээ. Холболтын тэрхүү ариун нандин хүч эдүгээ Сүмтэй хамт байгаа болно. Энэхүү эрх мэдлийн ач холбогдлыг мэддэг хүмүүсийн бясалгалаас илүү эрхэм нандин зүйл гэж үгүй болой. Юу ч үүнээс илүү ойр дотно байдаггүй. Аль ч цаг үед дэлхий дээр холболтын энэхүү хүчийг атгадаг харьцангуй цөөхөн байдаг нь ариун сүм болгонд холболтын хүч өгөгдсөн ах нар юм. Есүс Христийн Хожмын Үеийн Сүмийн Ерөнхийлөгч, бошиглогч, үзмэрч, илчлэгчээс эсвэл үүнийг бусдад хүртээхээр түүний томилсон хүмүүсээс биш бол хэн ч үүнийг өөр бусдаас авч чадахгүй.

## *“Бид Их Эзэнийг Харсан. . . .”*

Елиагийн эргэж ирсэн өдөр бол 1836 оны Дөрөвдүгээр сарын 3-ны Ням гарагийн үдээс хойш байлаа. Көөртландын Ариун Сүмд ариун ёслолын цуглаан болж байлаа. Тэр үдээс хойшийг Бошиглогч доорх энгийн үгсээр дүрсэлсэн байдаг:

Чимээгүй залбиралд би Их Эзэний Зоогийг Сүмд өргөхөд туслуулж, үүнийг энэ өдөр онцгой эрх үүргээ ариун нандин ширээний дэргэд гүйцэтгэж асан Арван Хоёроос хүлээн авч байлаа. Ах нартаа энэхүү үйлчлэлийг гүйцэтгэсний дараа би индэрт буцаж очиход хөшиг доош бууж, би Оливер Каудрийн хамт чанд бөгөөд чи-

мээгүй залбирахаар доош бөхийв. Залбирлаас боссоны дараа дараах үзэгдэл бид хоёрт хоёуланд нь нээгдсэн болой. (С ба Г 110, оршил.)

Бидний оюун бодлоос хөшиг авагдан, мөн бидний ойлголтын мэлмий нээгдэв.

Их Эзэн индрийн дээгүүр бидний өмнө зогсож байхыг бид харсан бөгөөд түүний хөл дор хулсан шаргал өнгөтэй, шижир алтан тавиур байв.

Түүний нүд галын дөл лугаа адил байв; толгойн үс нь цас лугаа адил цав цагаан ажгуу, түүний царай нарны гэрлээс ч хурцаар гялалзаж байлаа; мөн түүний дуу хоолой нь агуу их ус нүргэлэх лугаа адил, бүр Жэховагийн дуу хоолой байв:

Их Эзэн би эхнийх бөгөөд эцсийнх бөлгөө; Би амьд тэрбээр болой, би алагдсан тэрбээр болой хэмээн хэлжээ. Тэр бол Эцэгийн өмнө бидний өмгөөлөгч мөн.

Болгоогтун, нүглүүд чинь та нарт өршөөгдсөн болой; та нар миний өмнө цэвэр ариун болой; тиймийн тул, тэргүүнээ өргөж баясагтун.

Ах дүүсийн чинь зүрх сэтгэл баясаг, мөн энэ өргөөг өөрсдийнхөө хүч чадлаар миний нэрэнд байгуулсан бүх хүмүүсийн зүрх сэтгэл баясаг.

Учрыг болгоогтун, би энэ өргөөг хүлээн авлаа, мөн миний нэр энд байх болно; мөн бибээр энэ өргөөнд өөрийнхөө хүмүүст өөрийгөө нигүүлсэлд тунхаглах болно.

Тийм ээ, хэрэв миний хүмүүс зарлигуудыг минь сахиж, энэ ариун өргөөг эс буртаглах аваас, би үйлчлэгчиддээ хүрч ирэн, мөн өөрийнхөө дуу хоолойгоор тэдэнтэй ярих болно.

Тийм ээ хэдэн мянга мөн хэдэн арван мянган хүмүүсийн зүрх сэтгэл, цутгагдан ирэх тэрхүү адислалууд хийгээд энэ өргөөнд миний үйлчлэгчдийн хүртсэн индаументийн улмаас агуу ихээр баясах болно.

Энэхүү өргөөний нэр алдар гадаадын нутгуудад тархах болно; мөн энэ бол миний хүмүүсийн тэргүүн дээр цутгагдах тэрхүү адислалын эхлэл бөлгөө. Бүр тийм буюу. Амэн.

Энэхүү үзэгдэл дууссаны дараа, тэнгэр дахиад Иосеф Смит, Оливер Каудри нарт нээгдэн, Мосе тэд-





*Сэлэсчел Өрөө, Солт Лэйкийн Ариун Сүм*

ний өмнө гарч ирэв. Мөн газар дэлхийн дөрвөн зүгээс Израилын цугларалтын хийгээд умард нутгаас арван овгийг удирдан хөтлөх түлхүүрүүдийг тэдэнд итгэл хүлээлгэн өгсөн билээ.

Үүний дараа Елиа хүрч ирэн тэдэнд Абрахамын сайн мэдээний эрин үеийг тунхаглаж, тэдний дараах бүх үеийнхэнд хийгээд тэдний үр садад адислагдах болно гэдгийг хэлсэн билээ.

Энэхүү үзэгдэл дууссаны дараа өөр нэгэн агуу их хийгээд алдартай үзэгдэл тэдэн дээр ирэв; үхлийг үзэлгүйгээр тэнгэрт аваачигдсан бошиглогч Елиа тэдний өмнө зогсч байлаа.

Болгоогтун, Их Эзэний агуу их хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө тэрээр [Елиа] илгээгдэх ёстойг нотлон Малахийн амаар хэлэгдсэн тэр цаг үе-

Эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүү нь, мөн хүүхдүүдийнхийг эцгүүд рүү нь эргүүлэх, эс тэгвээс бүх дэлхий зүхлээр цохигдсон байх тэрхүү цаг үе бүрнээрээ ирлээ хэмээн тэрээр хэлэв.

Тийм учраас, энэ эрин үеийн түлхүүрүүд та нарын гарт даатгагдсанн бөлгөө; мөн үүгээр Их Эзэний агуу их хийгээд аймшигт өдөр ойртсоныг, бүр хаалган дээр ирээд байгааг та нар мэдэж болно. (С ба Г 110:1–16.)

Энэ явдал тохиосон билээ! Энэ гайхамшигт үйл явдалд дэлхий анхаарал тавьсангүй, гэвч энэ нь нэгэн цагт амьдарч байсан буюу амьдрах хүн бүрийн хувь заяанд нөлөөлөх болно. Юмс чимээгүйхэн болсоор байна. Сүм маань ариун сүмүүдийг байгуулагч сүм боллоо.

Дэлхийд энд тэндгүй хүмүүс, байгууллагууд болон нийгэмлэгүүд үе удмаа судалж мэдэхийг сонирхох болсон нь аяндаа бий болсон зүйл гэмээр ажээ. Көөртландын Ариун Сүмд Елиаг үзэгдсэнээс хойш энэ бүхэн болж байгаа билээ.

1836 оны Дөрөвдүгээр сарын 3-ны яг энэ өдрөөс эхлэн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэж эхэлсэн юм. Энэ үеэс хойш ёслолууд нь цаг зуурын биш, байнгын болсон билээ. Холболтын хүч бидэнтэй хамт байлаа. Үнэ цэнээрээ холболтын хүчнээс давж гарах өөр эрх мэдэл гэж үгүй билээ. Энэхүү хүч нь амьд байгаа хүмүүс болон

нас барагсдын аль алиных нь төлөө зохих эрх мэдэлтэйгээр гүйцэтгэгддэг бүх ёслолуудыг утга учиртай, мөнхийн хувиршгүй чанартай болгодог билээ.

## БҮХ ЗҮЙЛ ЗОХИХ ЁСООР БОЛОВ

Көртландын Ариун Сүмд тохиосон сэтгэл доглуулам үйл явдлын дараах бэрхшээл хүндрэлүүд хийгээд хавчлага мөрдлөг нь Гэгээнтнүүдийг нүүхэд хүргэсэн. Тэд хаана ч байлаа гэсэн Их Эзэн ариун сүм барих төлөвлөгөөнүүдийг тэдэнд илэрхийлж байв. Энэ нь Миссуригийн Индепендэс хийгээд Фар Вест аль алинд нь үнэн байлаа. Энэ үед хавчлага урьд үзэгдээгүй их уур хилэнгээр Гэгээнтнүүд дээр бууж, үүний улмаас тэд Иллинойсын Новуу руу зугтав. Энд уг илэрхийлэлт болон Их Эзэний өргөө байгуулах зарлиг дахин иржээ.

Өргөөг барихын зорилго нь ёслолуудыг илэрхийлэх явдал мөн гэдгийг Их Эзэн тайлбарлажээ. “Мөн чандлан би та нарт хэлж байна, бибээр өөрийн ёслолуудыг энд өөрийн хүмүүст илчилж болохын тулд энэ өргөө миний нэрэнд баригдсан байг; учир нь дэлхийн сууринаас өмнө нуугдмал байсан зүйлүүдийг, цаг хугацааны бүрэн байдлын эрин үед хамаарах би өөрийн хүмүүст илчлэхийн тулд зүй ёсоор анхаарна.” (С ба Г 124:40–41.)

Ариун сүм нь “та нарын тосолгоонууд мөн та нарын угаалгууд, нас барагсдын төлөөх та нарын усан баталгаанууд, та нарын онцгой хүндэтгэлийн хуралдаинууд мөн Левийн хөвгүүдэд хийгдсэн та нарын золиослолуудын төлөөх та нарын дурсгалууд, мөн ярианууд мөн өөрсдийн дүрмүүд хийгээд шүүлтүүдийг та нар хүлээн авдаг хамгийн ариун газрууд дахь та нарын зөн билгүүдийн тул, илчлэлтүүдийн хийгээд Сионы суурийн эхлэлийн тул мөн алдар суу, хүндэтгэлийн тул, мөн үүний бүх хотуудын индаументууд нь . . . миний ариун нэрэнд барихаар миний хүмүүс байнга зарлигдуулдаг миний ариун өргөөний ёслолыг” тэдний хувьд хөтлөн явуулдаг газар байх болно хэмээн Тэрээр дурдсан байдаг. (С ба Г 124: 39.)

Сүмд бидний гүйцэтгэдэг ёслолуудын дотор: усан баталгаа, ариун ёслол, нялх хүүхдэд нэр өгөх болон адислах, өвчтөнийг адислах, Сүм дэх дуудлагуудад онцгойлон адис-



Сэглэсчл Өрөө, Ка-лифорнийн Сан Диего Ариун Сүм

лах, албан тушаалуудад томилох явдал багтдаг. Түүнээс гадна ариун сүмүүдэд хийгддэг өндөр хэмжээний ёслолууд байдаг. Эдгээрт угаалга, тосолгооны ёслолууд, индаумент (ариун сүмийн хишиг хүртэх), мөн ариун сүмийн гэрлэлт хэмээн ерөнхийд нь нэрлэдэг холболтын ёслолууд багтдаг.

Сүмийн гишүүд бидэнд эдгээр ёслолууд хэр зэрэг чухал вэ?

Эдгээр ёслолуудгүйгээр та нар аз жаргалтай байж чадах уу, гэтэлгэгдэж чадах уу, өргөмжлөгдөж чадах уу? Хариулт нь: эдгээр ёслолууд зөвлүүштэй буюу хүсүүштэй төдийгүй бүр чухал шаардлагатай гэдгээс ч илүү юм. Бүр зайлшгүй чухал буюу амин чухал гэдгээс ч илүү эрхэм юм. Эдгээр нь та бидний хүн болгоны хувьд *шийдвэрлэгч ач холбогдолтой* юм.

Дараах асуултыг өөрөөс нь олонтаа асуудаг байсан хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ.

“Эдгээр бүх ёслолуудыг хийлгэхгүйгээр бид аврагдаж болохгүй юу?” Үгүй ээ, аврал бүрнээрээ байхгүй байх болно гэж би хариулахсан. “Миний Эцэгийн өргөөнд олон харш бий, мөн би та нарт орон байр бэлдэхээр явна” хэмээн Есүс хэлжээ. Энд *Өргөө* гэснийг хаант улс хэмээн орчуулбал зохино; мөн тэрхүү хамгийн дээд харшид өргөмжлөгдөх хэн боловч сэлэсчелийн хуулийг, мөн түүнчлэн бүхэл хуулийг дагах ёстой. (*History of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, ed. B.H. Roberts, 7 vols. [Salt Lake City: The Church of Jesus Christ of Latter-day Saints, 1949], 6:184.)

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит хэлэхдээ:

Энэ Сүмд та ямар албан тушаалтай байх нь надад чухал биш; та төлөөлөгч байж болно, та патриарх, дээд зөвлөх, эсвэл өөр хэн ч байлаа гэсэн хэрэв та Их Эзэний ариун сүмд орж бошиглогчийн ярьсан эдгээр ёслолуудыг хүлээн аваагүй бол пристийн зэргийн бүрэн бүтэн байдлыг та хүлээн авч чадахгүй. Их Эзэний ариун сүмээс гадуур хүмүүн санваарын бүрэн бүтэн байдлыг олж авч чадахгүй. (Joseph Fielding Smith, *Elijah the Prophet and His Mission* [Salt Lake City, Deseret Book Co., 1957], page 46.)

Ариун сүмд хийдэг илүү дээд ёслолуудын тухай бид өмнө өгүүлсэн билээ. Эдгээр ёслолууд индаументийг багтаадаг. Индаумент хүртээх гэдэг нь баяжуулах, маш их үнэ цэнэтэй ямар нэг зүйлийг урт удаан хугацаагаар өгөх гэсэн утгатай. Ариун сүмийн индаументийн ёслолуудаар баяжуулах нь гурван аргаар хэрэгждэг: (а) ёслол хүлээн авч байгаа хүнд хүч нь Бурханаас өгөгддөг. “Хүлээн авагчид индаументийг дээд тэнгэрээс хүртдэг.” (б) Хүлээн авагч нь мөн мэдээлэл ба мэдлэгээр индаумент хүртдэг. “Тэд Их Эзэний зорилгууд хийгээд төлөвлөгөөнүүдийн талаар мэдлэгтэй болдог.” (*Mormon Doctrine*, page 227.) (в) Тахилын ширээний дэргэд холболт хийлгэх үедээ хүн алдар суу билэгт адислалууд, хүчнүүд хийгээд хүндэтгэлийг индаументийнхаа нэг хэсэг болгон хүлээн авагч байдаг.

Индаументийн талаар хэвлэлд нийтлэгдсэн хоёр тодорхойлолт байдгийн эхнийх нь Ерөнхийлөгч Бригэм Янгийнх юм:

Товчхон тодорхойлолт өгөхийг зөвшөөрнө үү. Таны индаумент бол таны хувьд зайлшгүй чухал тэдгээр бүх ёслолуудыг Их Эзэний өргөөнд хүлээж авах явдал бөгөөд энэ нь таныг энэ амьдралаа орхисны дараа харуул мэт зогсох сахиулсан тэнгэрүүдийн дэргэдүүр өнгөрөхдөө Ариун Санваарт хамаарах түлхүүр үгс, тэмдэг ба дохионуудыг тэдэнд өгч, газар дэлхий ба тамыг үл хайхран мөнхийн өргөмжлөлийг хүртэн Эцэгийн дэргэд буцаж очих боломжийг танд олгох болно. (*Discourses of Brigham Young*, comp, John A. Widtstoe [Salt Lake City, Deseret Book Co., 1971], p.416.)

Ахлагч Жэймс Е.Талмаж индаументийг ийнхүү тайлбарласан байна:

Өнөө үеийн ариун сүмүүдэд үйлчлэгдэж буй *Ариун Сүмийн индаумент* нь өнгөрсөн эрин үеүдийн ач холбогдол хийгээд дэс дараалал мөн хүн төрөлхтний түүхэнд хамгийн агуу их нь болох энэ эрин үеийн ач холбогдолд хамаарах заавраас бүрддэг бөлгөө. Зааврын энэ чиглэл нь бүтээлтийн үеийн хамгийн гарамгай үйл явдлууд, бидний анхны эцэг эхчүүдийн Эдэний Цэцэрлэг дэх нөхцөл, тэдний дуулгаваргүй байдал хийгээд үүний улмаас тэрхүү жаргалангийн орноос

хөөгдсөн, ганцаардмал хийгээд дүнсгэр дэлхийд, хөлсөө асгаруулан хөдөлмөрлөж амьдрах болсон тэдний нөхцөл байдал, агуу нүгэл хилэнц түүгээр цагаатгагдаж болох гэтэлгэл, агуу их урвалтын үе, Сайн Мэдээ эрт дээр үеийн бүхий л хүч хийгээд онцгой эрхээрээ дахин сэргэсэн, хувь хүний туйлын цэвэр ариун хийгээд чухал шаардлагатай байдал ба эдүгээгийн амьдралд өөрийгөө зориулахуй, түүнчлэн Сайн мэдээний шаардлагуудыг чанд мөрдөх явдлыг багтаадаг билээ. (James E. Talmage, *The House of the Lord* [Salt Lake City, Bookcraft, 1962], pages 99–100; hereafter cited as *The House of the Lord* .)

Та ариун сүмд орж өөрийнхөө индаументийг хүртэснээр дэлхийг бүтээж хүн амьдруулсан Их Эзний зорилгууд хийгээд төлөвлөгөөнүүдтэй холбогдох зааврыг та хүлээж авах болно гэдгийг Ахлагч Талмажийн энэхүү нотолгоо тодорхой харуулж байна. Өргөмжлөлийг хүртэхийн тулд та юу хийх ёстойг заалгах болно.

Индаументийн адислал нь бүрэн өргөмжлөгдөхийн тулд зайлшгүй шаардлагатай. Хожмын үеийн Гэгээнтэн бүр энэ адислалыг хүртэхийн тулд зохистой байж үүнийг олж авахын төлөө эрэлхийлэх ёстой.

Ариун сүмд угаалга, тосолгооны ёслолуудыг оршил ёслолууд гэж нэрлэх нь олонтаа байдаг. Бидний зорилгын хувьд гэвэл зөвхөн дараах зүйлийг хэлэх нь хангалттай байх болно: индаументтай холбоотой угаалга болон тосолгооны ёслолууд нь мөн чанараараа нэн их бэлэгдлийн шинжтэй хэдий ч тодорхой амлалтууд, шууд адислалууд мөн түүнчлэн ирээдүйн адислалууд болдог.

Эдгээр ёслолуудтай холбоотойгоор та ариун сүмд ариун сүмийн өмсгөлийг албан ёсоор өмсөх бөгөөд үүнтэй холбоотой гайхамшигт адислалууд амлагддаг билээ. Эдгээр ёслолууд хэрхэн гүйцэтгэгдэхийг мөн амлагдсан адислалууд хийгээд тэдгээр нь ямар нөхцөлд хэрэгжихийг та анхааралтай сонсож, эргэн санахыг хичээх нь чухал юм.

Холболтын ёслол бол гэр бүлүүдийг мөнхөд холбодог ёслол юм. Ариун сүмийн гэрлэлт бол холболтын ёслол юм. Иргэний журмаар гэр бүл болсны дараа хосууд ариун сүмд холболт хийлгэхэд, ариун сүм дэх холболтоос өмнө төрсөн хүүхдүүд нь гэрээнд төрөөгүйн улмаас товчхон хийгээд ариун нандин ёслолоор тэдэнтэй холболт хийлгүүлдэг.

Амьдрал тань бүрэн зохих ёсоороо байгаа нь тов тодорхой байг. Энэ нь гагцхүү таны ариун сүмийн адислалуудаас, таны ёслолуудаас ирдэг, учир нь “үүний ёслолуудад бурханлиг чанарын хүч үзүүлэгддэг.” (С ба Г 84:20.)

## НАНДИН ГЭРЭЭНҮҮД

Эдүгээ Сургаал ба Гэрээний 132 дугаар хэсэг хэмээн нэрлэгддэг илчлэлтэд Их Эзэн мэдэгдэхдээ:

Учрыг болгоогтун, шинэ бөгөөд үүрдийн гэрээг би та нарт илчилж байна; мөн хэрэв та нар тэрхүү гэрээг эс сахиваас, тэгвэл та нар хараагдах болно; учир нь энэ гэрээг эсэргүүцэх хэнд ч гэсэн тэрчлэн миний алдар сууд орох нь эс зөвшөөрөгдсөн байх болно.

Учир нь миний гараас адислалыг хүлээн авах тэд бүгд тэрхүү адислалын тул өгөгдсөн хуулийг, мөн үүний нөхцөлүүдийг дэлхийн суурины өмнөөс үндэслэгдэн бий болсноор нь баримтлах ёстой. (С ба Г 132:4–5.)

Ерөнхийлөгч Иосеф Филдинг Смит шинэ бөгөөд үүрдийн гэрээг дараах үгсээр тодорхойлжээ:

Шинэ бөгөөд үүрд үргэлжлэгч гэрээ гэж юу вэ? Шинэ бөгөөд үүрдийн гэрээ гэдэг нь чухам юу юм бэ гэдэг талаар сүмийн зарим гишүүд буруу ойлголттой буюу буруу мэдээлэлтэй байдгийг хэлэхэд харамсалтай байна. *Шинэ бөгөөд үүрдийн гэрээ гэдэг бол сайн мэдээний бүх гэрээнүүд хийгээд үүргүүдийн нийлбэр дүн юм.* (Joseph Fielding Smith, *Doctrines of Salvation*, 3 vols. [Salt Lake City: Bookcraft, 1954–56], 1:156; hereafter cited as *Doctrines of Salvation*.)

Энэ гэрээ нь ариун сүмд гүйцэтгэгддэг сайн мэдээний хамгийн дээд бүх ёслолуудыг өөртөө багтаадаг. Ерөнхийлөгч Смитийн үгийг энд дахин иш татъя;

Эдүгээ шинэ бөгөөд үүрд мөнх үргэлжлэгч гэрээний нарийвчилсан тод томруун тодорхойлолт бий болоод байна. Энэ бол юм бүхэн буюу сайн мэдээний бүрэн дүүрэн байдал юм. Иймээс гэрлэлт зохих ёсоороо хийгдэж, усан баталгаа, пристийн зэргийн ёслол, бусад бүх зүйл: энд өгөгдсөн түүний хуулийн дагуу амлалтын Ариун



Сүнсээр холбогддог Есүс Христийн сайн мэдээнд хамаарах гэрээ болгон, үүрэг болгон, мөн гүйцэтгэл болгон нь шинэ бөгөөд үүрд мөнх үргэлжлэгч гэрээний нэг хэсэг мөн. (*Doctrines of Salvation*, 1:158.)

Өмнө (Сургаал ба Гэрээ 132:4) дурдсан шүлэгт Их Эзэн өчүүхэн ч эргэлзээгүй тов тодорхойгоор хэлэхдээ; “. . . энэ гэрээг нэг ч хүн няцааж чадахгүй бөгөөд түүний алдар сууд орох нь хэнд ч үл зөвшөөрөгдөх болно” гэжээ.

Ариун сүмд орохоор явж байгаа хүмүүс өөрсдийнхөө хийгээд бусдын өргөмжлөлд хамаарах өвөрмөц гэрээнүүд хийгээд үүргүүдийг өөрсөд дээрээ хүлээн авах онцгой эрхтэй байдаг. Ахлагч Жэймс Е.Талмаж ийн бичжээ:

Индаументийн ёслолууд нь ариун шударга журам хийгээд ариун явдлын хуулийг чандаар мөрдөн сахих, энэрэнгүй байх, нинжин сэтгэлтэй, тэвчээртэй, цэвэр ариун байх, авъяас чадвар болон эд материаллаг зүйл аль алиныг нь зориулах, үнэнийг дэлгэрүүлж, гарал угсаагаа өргөж явах; үнэний зарчимд зориулах явдлыг сахих; мөн газар дэлхий өөрийнхөө Хаан, Их Эзэн Есүс Христийг хүлээн авах тэрхүү агуу их бэлтгэлд бүхий л боломжтой аргаар хувь нэмрээ оруулахыг эрэлхийлэх зэрэг үүргүүдийг хувь хүмүүс өөрсөд дээрээ хүлээж, гэрээ байгуулан амлалт өгөхөөр болгодог билээ. Гэрээ болгоныг хийж, мөн үүрэг болгоныг авснаар, тэдгээрийн нөхцлүүдийг үнэнчээр сахихад ирэх адислал амлагдан тунхаглагддаг билээ. (*The House of the Lord*, page 100.)

Бид өөрсдийн цаг, авъяас болон эд материалаа Түүний хаант улсад зориулахаар Их Эзэнтэй гэрээ байгуулдаг.

Бид бол гэрээт хүмүүс юм. Бид цаг хугацаа, мөнгө, авъяас чадварынхаа нөөцүүдийг өөрсдийгөө бүгдийг нь хийгээд эзэмшиж байгаа бүхнээ газар дэлхий дээрх Бурханы хаант улсын ашиг тусын тулд зориулахаар гэрээ байгуулдаг. Энгийн үгээр хэлбэл, сайн сайхныг хийхээр гэрээ байгуулдаг. Бид бол гэрээт хүмүүс юм, мөн ариун сүм бол бидний гэрээнүүдийн төв нь билээ. Ариун сүм бол гэрээний эх сурвалж юм.

Ариун сүмд очигтун. Та ариун сүмд очих хэрэгтэй. Энд, нас барсан хэн нэгнийг төлөөлснөөрөө та өөрийнхөө хийсэн гэрээнүүдийг өөрийнхөө өмнө дахин нэгтгэн дүгнэх болно. Их Эзэний өргөөтэй холбоо бүхий тэрхүү сүнслэг агуу их адислалуудыг та оюун ухаандаа батжуулах болно.

Гэрээнүүд хийгээд сайн мэдээний ёслолуудад үнэнч итгэлтэй байгтун. Та амьдралын жамаар урагшлахдаа эдгээр ариун нандин ёслолуудад тавигдах шаардлагыг алхам алхмаар хангагтун. Тэдгээртэй холбогдсон гэрээнүүдийг эрхэмлэн дээдэл. Үүнийг хийснээрээ та баяртай байх болно.

Тэгвэл амьдрал тань зохих ёсоороо бүх зүйл зохих дэс дарааллаараа, зохих зэрэг дэгээрээ, зохих байрандаа жигдэрсэн байх болно. Гэр бүл тань хэзээ ч бутрахгүйгээр зохих ёсоороо холбогдсон байх болно.

Ариун сүмд таны хүсэн хүлээж болох тэрхүү адислалууд нь гэрээнүүд хийгээд ёслолуудын төвд буй. Гэрээнүүдээ сахигч гэсэн нэрэндээ дүйхүйцээр бид зохистой байх нь Их Эзэнийг баярлуулах нь дамжиггүй.

## *ЭСЭРГҮҮЦЭЛГҮЙ БАЙНА ГЭЖ ҮГҮЙ*

Ариун сүмүүд бол Сүмийн сүнслэг байдлын хүчирхэг-жилтийн яг төв нь билээ. Энэхүү ариун нандин хийгээд сүнслэг урмаар өдөөгдсөн ажилд оролцохоор биднийг эрэлхийлэх үед дайсагнагчид бидэнд Сүмийн хувьд ч, хувь хүмүүсийн хувьд ч бидэнд саад учруулах гэж оролдоход бид бэлэн байх ёстой. Тэр саад нь анхны үед байсан тэрхүү аймшигт мөрдлөг хавчлагаас эхлээд уг ажлыг огт сонирхохгүй байх зэргээр олон янз байж болно. Сүүлчийнх нь хамгийн их аюултай, мөн ариун сүмийн ажлыг эсэргүүцэхээс илүү сулруулагч нөлөөтэй байж болох юм.

Ариун сүмийн ажил нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд, мөн Сүмд бүхэлд нь нэн их сүнслэг хүчний эх сурвалж болдог учраас их эсэргүүцэлтэй тулгардаг билээ.

Логаны Ариун Сүмийн тулгын чулууг онцгойлон адислахад Ерөнхийлөгч Жорж К.Каннон энэ мэдэгдлийг хийжээ:

Ариун Сүмийн суурь тавьсан чулуу болгон нь, мөн Их Эзний журмын дагуу барьж дууссан Ариун Сүм болгон Түүний Ариун Санваарыг илэрхийлж, газар дэлхий дээр Сатаны хүчийг бууруулж, мөн Бурханы хийгээд Бурханлиг хүчийг нэмэгдүүлж, бидний өмнөөс тэнгэрийг хүчирхэг хүчээр хөдөлгөн, Мөнхийн Бурхадын хийгээд тэдгээрийн дэргэд орших тэдгээрийн адислалуудыг бидэн дээр доош уриалан дуудаж байна. (“The Logan Temple,” *Millennial Star*, 12 nov. 1877, page 743.)

Сүмийн гишүүд сэтгэлийн зовлонд унах буюу сэтгэл санаанд нь дарамт учруулагч учир холбогдол бүхий шийдвэр гаргах үед тэд ариун сүмд очдог нь нийтлэг зүйл юм. Энэ нь бид өөрсдийн сэтгэл зовоосон зүйлээ авч очвол зохих тэр газар мөн. Ариун сүмд бид сүнслэг хэтийн төлөвийг хүлээн авч чадна. Тэнд ариун сүмийн үйлчлэлийн үед бид “дэлхийгээс гадна” байдаг.

Эдгээр үйл явдлуудын үнэ цэнийн томоохон хэсэг бол хэн нэгний өөрсдийнхөө төлөө хийж чадахгүй ямар нэг зүйлийг бид тэдний төлөө хийдэгт оршино. Нас барсан хүний төлөө бид индаумент хийлгэхдээ Их Эзэнээс бидэнд туслахыг хичээнгүйлэн хүсч залбирахад бид яагаад ч юм бага зэрэг эргэлзээ төрдөг явдал бий. Хэрэв ариун сүмд ойр байгаа бол гэрлэсэн залуу хосууд шийдвэр гаргах үедээ ариун сүмийн хэсэгт оролцох нь агуу их үр дүнг өгнө. Ариун сүм дэх сүнслэг уур амьсгалын тухайд гэвэл тэнд цэвэршүүлэгч, тодорхой болгогч ямар нэг зүйл байдаг.

Заримдаа бидний оюун ухаан асуудал бэрхшээлийн дарамтад орох нь бий, мөн бид тодорхой байдлаар ухаарч бодох буюу харах аргагүй атлаа тэр даруй анхаарал тавихыг шаардагч өдий төдий зүйл байдаг. Анхаарал сарниулах зүйл ариун сүмд алга болж, эргэлзээний манан арилж, мөн бид өмнө нь харж чаддаггүй байсан зүйлүүдээ “харж” чаддаг болж, өмнө нь мэддэггүй байсан бэрхшээл зовлонгууд дундуураа туулан гарах арга замыг олдог.

Биднийг ариун сүмийн ариун нандин ёслолын ажлыг гүйцэтгэхэд Их Эзэн адислах болно. Адислалууд нь ариун сүмд үйлчилсэн бидний үйлчлэлээр хязгаарлагдахгүй. Бид өөрсдийн бүхий л ажил үйлсүүдэд адислагдах болно. Их Эзэн бидний үйл хэрэгт сүнслэг хийгээд эд материал-

лаг талын аль алинд нь анхаарал тавих тэрхүү боломж бидэнд нээгдэх болно.

## ХӨШИГ ТИЙШ

Бид ариун сүмүүдийг яагаад барьдаг вэ, мөн ёслолууд яагаад бидэнд шаардлагатай байдаг вэ гэдэг талаар зарим ойлголттой байх ёстой. Үүний дараа бид сүнсний хувьд чухал асуудлуудаар зааварлагдаж, мөн гэгээрсээр байх болно. Энэхүү гэгээрэл нь алхам алхмаар бага багаар ахих замаар гэрэл ба мэдлэгийн бүрэн байдлыг бид хүлээн авах хүртэл ирдэг билээ. Энэ нь бидэнд хүн болгонд маань агуу их хамгаалалт болдог. Энэ нь бас Сүмийн хувьд ч хамгаалалт болдог.

Ариун сүмийн ажил хийгээд үүнд түлхэц өгөгч удмын судалгаанаас илүү энэ Сүмд хамгаалалт болох ажил үгүй билээ. Сүнслэг байдлыг сайжруулагч үүнээс өөр ажил гэж үгүй билээ. Бидэнд илүү хүчийг өгөгч өөр ажил гэж үгүй билээ. Зөв шударга ёсны илүү өндөр жишгийг шаардагч өөр ажил гэж үгүй билээ.

Ариун сүм дэх бидний ажил хувь хүний хувьд ч хүмүүсийн хувьд ч аль алинд нь бидэнд бамбай, хамгаалалт болдог билээ.

Энэ нь Түүнтэй байгуулах гэрээнд биднийг оруулдаг тиймийн тул бид гэрээт хүмүүс болдог ариун сүмийн ёслолуудад байдаг билээ.


Хэрэв бид ариун сүмийн ёслолын ажлын талаар илэрхийлэлт хүлээн авбал хэрэв бид аливаа шалтаг, өөрийгөө зөвтгөх явдалгүйгээр гэрээнд орвол Их Эзэн биднийг хамгаалах болно. Амьдралын бэрхшээлүүдэд хангалттай сүнслэг урмыг бид хүлээн авах болно.

Ариун сүмүүдэд хамаарах ажил үнэн юм. Энэ нь хөшигний цаанаас илэрхийлэгдсэн бөгөөд илэрхийлэлт үргэлжилж байна.

Илэрхийлэлт нь ариун сүмийн ажлын тухай Сүмийн гишүүн нэг бүрт тус тусад нь ирж болно.

Тиймээс ариун сүмд очигтун очоод адислалуудаа хүртэгтүн. Энэ бол ариун нандин ажил юм.





ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



36793 363